



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 08 сарын 14 өдөр

Дугаар А/533

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4."А", Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Худалдах авах ажиллагааны хууль болон гэрээ байгуулах иргэний хуулийг үндэслэн Мөнххайрхан сумын соёл, спортын төвийн барилга угсралтын ажилд хоёр дахь удаагаа тендер зарлагдахад шалгарсан "Саруул цамхаг" ХХК-тай барилгын бүтэц хийц үнийн асуудлаар зөвшилцөх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга: Ц. Ганданповрон- аймгийн Засаг даргын Тамгын газрын
хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд.

Ш.Нохойжав -Орон нутгийн өмчийн газрын дарга

Н.Ганзориг- Хууль эрхзүй хэлтсийн дарга

Ц.Даваасамбуу-Орон нутгийн өмчийн газрын Ахлах
мэргэжилтэн

Нарийн бичгийн

дарга: Ц.Сувдаа- аймгийн Засаг даргын Тамгын газрын
хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн
хэлтсийн мэргэжилтэн

2.Шалгарсан "Саруул цамхаг" ХХК-тай гэрээ байгуулахад тохирох шаардлагатай 300 хүний суудалтай соёлын төв, 15x28 харьцаатай спорт заалны барилгыг улсын төсөвт багтаан барих асуудлаар нэгдсэн зөвшилцөлд хүрч шийдвэр гаргахыг ажлын хэсгийн дарга /Ц.Ганданповрон/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ